

**МОНГОЛ ХЭЛНИЙ ХҮҮРНЭХ ӨГҮҮЛБЭРИЙН  
НЭГЭН БАЙМЖ УТГЫН ТУХАЙ<sup>1</sup>**

Б.Рагчаа\*

Аливаа өгүүлбэрийн нэгэн чухал онцлог нь ямар нэг баймж утгыг илтгэж үүгээрээ үг, холбоо үгээс ялгагдаж байдагт оршино.<sup>2</sup> Баймжгүй өгүүлбэр гэж байхгүйн

<sup>1</sup> Хэлбичгийн ухааны дэд эрдэмтэн, доцент Б.Рагчаа (1927-1980) багшийн бичсэн нэгэн өгүүллийг миний бие олон жил хадгалж байгаа билээ. Анхны эх ноорог нь 25-27 мөрөөр А4 хэмжээний бичгийн цаасан дээр машиндсан 9,5 тал өнгөн хувь байна. Энэхүү өнгөн хувийн эх дээр хожим харандаагаар засвар хийхдээ дөрөв дэх талын сүүлийн өгүүлбэрийн санааг үргэлжлүүлэн дэлгэрүүлж хөх бэхээр бичсэн нэг талыг нэмэн оруулж нийтдээ 10,5 тал болгосон ажээ. Үүнтэй холбоотой бяцхан дурсамж сөхье.

Б.Рагчаа багшийг 1976 оны үед МУИС-ийн Хэлбичгийн факультетын монгол хэлний тэнхимд багшаар ажиллаж эхэлсэн цагаас нь миний бие таних болсон билээ. Тэр үед тус тэнхим МУИС-ийн II байрны 360 тоот өрөөнд байдаг байлаа. Тэрбээр 1977-1979 онд Хэлбичгийн факультетын деканаар ажиллаж байв. Би 1978 оны хавар МУИС, УБДС-ийн оюутны эрдэм шинжилгээний хамтарсан хуралд нэг илтгэл бэлтгэн Рагчаа багшид үзүүллээ. Тэрбээр илтгэлийг маань хэтэрхий нуршуу, их өргөн хүрээтэй асуудал руу өнгөц байдлаар орсон байна хэмээн шүүмжилээд харин алсдаа дипломын зохиол болговол зүгээр юм байна гэлээ. Тэр ёсоор болж би 1979 онд академич Ш.Лувсанвандан, доцент Б.Рагчаа багш хоёроор удирдуулан “Орчин цагийн монгол хэлний тийн ялгалын утгазүйн харьцаа” сэдвээр дипломын ажил бичиж хамгаалсан билээ. Багш маань биднийг төгсөх ангид байхад “Хэлшинжлэлийн спецкурс” хичээлийг бас заасан юм. Би багшаас 1979 оны хавар энэ өгүүллийн эх нооргыг авсан болов уу. Энэ өгүүлэл урьд өмнө аль нэг сэтгүүл, номд хэвлэгдсэн эсэхийг би мэдэхгүй юм... Багшийн гэр 12-р хороололд байсан бөгөөд бие нь чилээрхүү байхад манай ангийн Д.Баярхүү, Л.Бэгзжав бид гурав гэрт нь очин уулзаж байж билээ... хэмээсэн үүгээр эл бяцхан дурсамжаа өндөрлөхийн хамт Б.Рагчаа багшийн эрдэм шинжилгээний ажлын талаар өөрийн мэдэхийн хэрээр товч дурдъя.

Б.Рагчаа багш 1958 онд МУИС-ийн монгол хэл, утга зохиолын анги төгсөж УБДС, МУИС-д багш, тэнхимийн эрхлэгч, деканаар ажиллаж байсан. 1972 онд “Орчин цагийн монгол хэлний бодит нэрийн холбоо үг” сэдвээр хэл бичгийн ухааны дэд докторын зэрэг хамгаалсан. Доцент цолтой. Манай орны ЕБС-ийн 5, 6, 7-р ангид үзэх монгол хэлний сурах бичгийн голлох зохиогчоор олон жил ажиллаж, 1960-1976 оны хооронд 3 ангийн сурах бичгийг 8 удаа шинэчлэн хэвлүүлсэн байна. Тухайлбал, “Монгол хэл” (Дунд сургуулийн V ангид үзнэ. Уб., 1960), “Монгол хэлний зүйн сурах бичиг” (Дунд сургуулийн VI ангид үзнэ. Уб., 1962, 1965, 1969, 1976) зэрэг сурах бичиг зохион хэвлүүлж 1966 онд хэвлэгдсэн “Орчин цагийн монгол хэлзүй” номд “Тусагдахуун, байц гишүүн, нийлмэл өгүүлбэрийн тухай ойлголт, энгийн нийлмэл өгүүлбэр” хэмээх хэсгийг бичиж хамтын зохиогчоор оролцжээ. Мөн эрдэм шинжилгээний олон арван өгүүлэл бичиж хэвлүүлсэн байна.

Б.Рагчаа багшийн мэндэлсний 80 жилийн ой өнгөрсөн онд тохиосон бөгөөд номын ачит багшаа эргэн дурсаж олон жил хадгалж байсан өгүүллийг нь хэвлүүлж байна. - Ю.Мөнх-Амгалан

\* Хэлбичгийн ухааны дэд эрдэмтэн

адил өгүүлбэргүй баймж гэж байх аргагүй юм гэж хэл шинжлэлд үздэг билээ. Хэл бүрд энэхүү баймж харьцаа нь янз бүр байдаг. Ер, баймж чанар гэдэг бол яригч этгээд уг ярьж буй зүйлээр илэрч буй бодит ертөнцийн юм үзэгдэлтэй өөрөө хэрхэн харьцаж буйг үзүүлдэг утга юм.<sup>3</sup> Монгол хэлний хүүрнэх өгүүлбэрийн тухайд таамаглах болон эргэлзэх, гайхах, болох ёстой, бодитой болж буй буюу бодит биш болох зэрэг янз бүрийн өнгө аясыг илтгэсэн баймж утгууд байна. Эдгээр баймж харьцаа бүр нь тус тусын илрэх хэлбэртэй байдаг. Бид энд монгол хэлний хүүрнэх өгүүлбэрийн энэхүү олон баймж утгаас зөвхөн нэгий нь товч авч үзэхийг оролдсон билээ.

Профессор Г.Д.Санжеев гуай монгол хэлний үйл үгийн хэлбэрийг судлахдаа цаг заах хэлбэр тухайлбал өнгөрсөн цагийн хэлбэрүүдийн илтгэх утгын хоорондын ялгааг тогтооход их хэцүү, үүний учир нь тэдгээр хэлбэрийн утга нь баймж утгатай зууралдсан байдагт оршино.<sup>4</sup> гэж тун зүйтэй тэмдэглэжээ. Гэвч тэр баймж утга нь чухам ямар утга юм бэ? гэдгийг тодорхой заагаагүй байна.

Монгол хэлний хүүрнэх өгүүлбэрт байх олон баймж харьцааны дотор нэгэн зонхилох харьцаа байдаг нь яригч этгээдэд уг өгүүлж буй юм үзэгдэл урьд нь мэдэгдэж байсан буюу эсвэл мэдэгдээгүй байсныг илтгэх харьцаа юм гэж бодож байна. Энэ харьцаа ямар ч хүүрнэх өгүүлбэрт заавал илрэн гарна. Жишээлбэл,

1. МАНАЙ ҮҮГЭЭР ӨЧИГДӨР ИХ БОРОО ОРЛОО.

2. МАНАЙ ҮҮГЭЭР ӨЧИГДӨР ИХ БОРОО ОРЖЭЭ гэсэн хоёр ижил утгатай өгүүлбэрийг харьцуулан үзэхэд хэл зүй-хэлбэрийн хувьд нэгдүгээр өгүүлбэрийн өгүүлэхүүн нь үйл үгийн өнгөрсөн цагийн –лөө нөхцөлөөр, хоёрдугаар нь –жээ нөхцөлөөр тус тус илэрснээс өөр ямар ч ялгаагүй байна. Утгын хувьд энэ хоёр өгүүлбэр хоёулаа мөн нэг л үйл явдал өнгөрч дууссаныг заажээ. Гэвч дээрх хэлбэрийн ялгаанаас үндэслэж энэ хоёр өгүүлбэрт баймж утгын ялгаа байх нь тодорхой билээ. Орчин цагийн монгол утга зохиолын ба ярианы хэлэнд энэ хоёр хэлбэрийг хутган хэлэлцэж болдоггүй нэгий нь заавал нэг үед, нөгөөгий нь өөр үед хэрэглэж байгааг ажиглаж болно. Үүнд яригч этгээд уг ярьж буй үйл явдлаа өнгөрч дуустал нь өөрөө тэр дунд байсан, өөрөө нүдээр үзэж, биеэр амсаж өнгөрүүлсэн бол –лаа, (-лоо, -лөө, -лээ) хэлбэрээр, тэр үйл явдал болж өнгөрөхөд яригч этгээд өөрөө байгаагүй, харин хожим нь мэдсэн санааг илтгэх гэвэл –жээ /-чээ/ нөхцөлөөр тус тус хэлбэржүүлж буй нь тодорхой байна. Яригч этгээд хэрэв “МАНАЙ ҮҮГЭЭР ӨЧИГДӨР БОРОО ОРЛОО” гэж хэлбэл сонсогч хүн тэр бороо орж байсан үед ярилцаж буй хүн маань өөрөө тэр газарт байсан, өөрөө түүнийг үзэж харж өнгөрүүлсэн юм байна гэсэн ойлголт авч, хэрэв “МАНАЙ ҮҮГЭЭР ӨЧИГДӨР БОРОО ОРЖЭЭ” гэвэл ярилцаж буй хүн тэр үед өөрөө байгаагүй буюу нүдээр үзээгүй хожим сая л тийм үйл явдал болсныг мэдээд хэлж буй юм байна гэсэн дүгнэлт хийнэ. Дашрамд хэлэхэд монголын судлалын ном зохиол, сурах бичгийн зүйлст монгол хэлний өнгөрсөн цагийн –жээ /-чээ/, /-в/, -лаа (-лоо, -лээ, -лөө) гэсэн гурван нөхцөл ямар утга илтгэдэг, ямар үед хэрэглэгддэг талаар харилцан адилгүй өөр өөр саналтай байсаар байна. Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтэн Г.Д.Санжеев –лаа (-лоо, -лөө, -лээ)-г болж өнгөрсөн үйл явдлыг зөвхөн дурсан ярьсан утгатай. Иймээс илтэд болж өнгөрсөн цаг буюу урьд өмнө нь бодитой болсон хоёрдохь хүүрнэх хэлбэр; -в-г ярьж буй үед буюу түүнээс өмнө төгссөн цаг, иймээс саяхан

<sup>2</sup> В.М.Солнцев. Язык как системно-структурное образование. М., 1977. 152-р тал.

<sup>3</sup> В.З.Панфилов. Взаимоотношение языка и мышления. М., 1971. 200-р тал.

<sup>4</sup> Г.Д.Санжеев. Сравнительная грамматика монгольских языков. Глагол. М., 1962. 189-р тал.

өнгөрсөн утгатай байна гээд –жээ (-чээ)-г гэнэт болж өнгөрсөн цагийг заана. Иймээс өөрийн эрхгүй гэнэт болсон гуравдахь хүүрнэх хэлбэр юм гэж тайлбарлажээ.<sup>5</sup>

Академиц Ш.Лувсанвандан 1950 онд бичсэн сурах бичгүүддээ -лаа (-лоо, -лөө, -лээ)-г одоо өнгөрсөн цаг, -жээ (-чээ)-г үргэлжилж өнгөрсөн, -в-г өнгөрөн төгссөн цагийн утгатай<sup>6</sup> гэж тайлбарласан бөгөөд сүүлийн үеийн бүтээлдээ дээрх нөхцөлүүдийг үйлийн ерөнхий хамаатуулах гэж нэрлээд –жээ (-чээ)-г мэдэгдэж өнгөрсөн цагт –лаа (-лоо, -лөө, -лээ)-г өнгөрөн үргэлжилсэн цагт, -в-г мэдэгдээгүй өнгөрсөн цагт хамаатуулах утгатай<sup>7</sup> гэж тайлбарлажээ.

Оросын нэрт монголч эрдэмтэн А.Бобровников -лаа (-лоо, -лээ, -лөө)-г сонсогчид урьд нь мэдэгдэж байсан буюу яригч этгээд түүний тухай сонин зүйл болгон яриагүй, мэдэгдэж буй юмыг дурсан ярих өнгөрсөн цаг, -в-г яригч этгээд үйл явдлуудыг дэс дараагаар нь ерийн тайван хүүрнэн ярьсан өнгөрсөн цаг, -жээ (-чээ)-г яригч этгээдэд өөрт нь урьд мэдэгдээгүй байгаад гэнэт мэдэгдэж өнгөрсөн цагийг тус тус заана гэж тэмдэглэжээ.<sup>8</sup>

МУИС-ийн багш доцент Л.Мишиг –жээ (-чээ)-г мэдэгдээгүй эрт өнгөрсөн цаг, -лаа (-лоо, -лээ, -лөө)-г дөнгөж сая өнгөрсөн цаг, -в-г түрүүн өнгөрсөн цаг гэж тайлбарлажээ.<sup>9</sup> Мөн тус сургуулийн багш дэд эрдэмтэн Г.Бадан, ахлах багш Л.Лхагва, Ж.Лувсандорж, багш Д.Баттулга нарын гадаад оюутанд зориулсан монгол хэлний сурах бичигт –лаа (-лоо, -лээ, -лөө); -в-г өгүүлэгч этгээд өөрөө үйлдсэн буюу оролцсон нүдээр үзсэн зүйлийг, -жээ (-чээ)-г өгүүлэгч этгээд уг үйлийг үйлдэхэд оролцоогүй буюу үзээгүй, мэдээгүй байгаад хожим мэдсэн тохиолдолд голлон хэрэглэнэ<sup>10</sup> гэж тайлбарлажээ. Ийнхүү дээрх хэлбэрүүдийн утгыг монгол хэлний судалгааны бүтээлүүд болон сурах бичиг зохиогчид янз бүрээр тайлбарласан байна. Гэвч эдгээрээс А.Бобровников гуай, доцент Л.Мишиг, дэд эрдэмтэн Г.Бадан, ахлах багш Л.Лхагва нарын дээр дурьдсан бүтээлдээ дэвшүүлсэн санал, орчин цагийн монгол хэлний баримт материалтай илүү сайн тохирч байгаа юм шиг санагдана. Гэвч миний бодоход дээрх эрдэмтэд мэдэгдсэн ба мэдэгдээгүй болсон, болох, болж буй цагийг зөвхөн өнгөрсөн цагийн гурван нөхцөлтэй холбон тайлбарласан нь арайхан учир дутагдалтай болсон мэт санагдах бөгөөд энэ хоёр зүйлийн баймж утга зөвхөн өгүүлбэрийн өнгөрсөн цаг дээр илрээд зогсохгүй, өгүүлбэрийн бусад цаг дээр тухайлбал, хүүрнэх өгүүлбэрийн одоо, ирээдүй цаг дээр, тэр ч байтугай цагт нэр, нэр өгүүлэхүүнтэй өгүүлбэр дээр нэгэн адил холбогдоно гэж бодож байна. Ерөөс хэлийг судлахад түүний утгын талыг хайхрахгүйгээр зөвхөн хэлбэрийн болон судалж болохгүй нь одоо нэгэнт тодорхой болжээ. Ялангуяа өгүүлбэрийг судлахдаа түүний утгыг заавал харгалзах хэрэгтэй болно. Зөвлөлтийн нэрт хэл шинжлэлч В.А.Звегинцев, өгүүлбэрийн онцлог шинж нь утга санаа илтгэх ба тодорхой орчин нөхцөлтэй байдагт оршино. Хэлийг утгаас гадуур судлах гэдэг нь алдарт зураач Рембрандтын зургийн дүрслэлийг тодорхойлохдоо зураачийн хэрэглэсэн будгийн нэрий нь зөвхөн тоочоод өнгөрсөнтэй адил юм гэж маш

<sup>5</sup> Г.Д.Санжеев Дурдсан зохиолын 188-189-р тал.

<sup>6</sup> Ш.Лувсанвандан. Монгол хэлний зүйн сурах бичиг. Уб., 1957 он. 87-р тал.

<sup>7</sup> Ш.Лувсанвандан. Орчин цагийн монгол хэлний бүтэц. Уб., 1968. 75-77-р тал.

<sup>8</sup> А.Бобровников. Грамматика монгольско-калмыцкого языка. Казань, 1849. 346-368-р тал.

<sup>9</sup> Л.Мишиг. Орчин цагийн монгол бичгийн хэлний дадлага хэл зүй. Уб., 1978. 119-126-р тал.

<sup>10</sup> Монгол хэл сурах бичиг. Уб., 1976. 47, 65-р тал.

оновчтой зүйрлэн нэрлээд утгагүй өгүүлбэр, өгүүлбэрийн утга гэж байх аргагүй юм<sup>11</sup> гэсэн билээ.

Дурдсан хоёр эсрэг тэсрэг баймж утга монгол хэлэнд үнэхээр байна гэдэг бидний таамаглал зөв бол энэ утга хүүрнэх өгүүлбэрийн зөвхөн нэг хэсэгт нь бус бүхий л хүүрнэх өгүүлбэрт нийтэд нь түгээмэл дэлгэрсэн байх ёстой билээ. Хэрэв ийм байж чадвал дурдсан таамаглал /гипотез/ зөв болох нь батлагдана гэж бодож байна. Иймээс бид цаашид яригч этгээдэд урьд нь мэдэгдэж байсан буюу мэдэгдээгүй хоёр зүйл баймж утга хүүрнэх өгүүлбэрийн бусад хэлбэр дээр хэрхэн илэрч буйг авч үзэхийг оролдъё. Энд бид өгүүлбэр зүйн цаг, үг зүйн цаг хоёрыг ялгаж үзэх хэрэгтэй гэж бодож байна. Өгүүлбэрзүйн цаг / синтаксическое время/ -ийн утга бүх л өгүүлбэрийн ерөнхий утгаар илрэх бөгөөд үйл үгийн цаг заах хэлбэрээс гадна бусад хэрэгслээр илрэн гарна. Гэтэл үг зүйн цаг / морфологическое время/ нь зөвхөн үйл үг, цагт нэрийн зүйл дээр байх бөгөөд өгүүлбэр зүйн цагаас явцуу ойлголт юм. Иймээс дээрх баймж утгыг бид хүүрнэх өгүүлбэрийн өгүүлбэр зүйн цаг гэдэг ойлголт дээр түшиглэн авч үзэх нь зүйтэй болно.

1. Орчин цагийн монгол хэлний одоо цагийн утгатай өгүүлбэрүүд яригч этгээдэд урьд нь мэдэгдэж болж буй буюу эсвэл урьд нь мэдэгдээгүй сая л мэдэгдэж буй баймж харьцааг заавал ялган заана. Үүнд, одоо цаг заах өгүүлбэрийн өгүүлэхүүн нь энгийн ба нийлмэл цаг заах хэлбэр / -на (-но, -нэ, -нө) буюу -ж, -н, -аад (-ээд, -оод, -өөд) байна, цагт нэр / -аа(-ээ, -оо, -өө)/, нэрлэхийн тийн ялгалтай нэрийн зүйлээр илэрдэг нь мэдээж билээ. Эдгээрээс энгийн ба нийлмэл цаг заах хэлбэрт үйл өгүүлэхүүн, БАЙНА гэдэг туслах үйл үггүй цагт нэр ба нэрийн зүйлээр илэрсэн өгүүлэхүүнтэй өгүүлбэрүүд нь цөм мэдэгдэж одоо болж буй баймж утгыг илтгэж, БАЙНА гэдэг туслах үйл үгтэй нэрийн зүйл цагт нэр, өгүүлэхүүнтэй өгүүлбэрүүд урьд нь мэдэгдээгүй одоо болж буй баймж харьцааг заадаг байна.

Жишээлбэл:

МЭДЭГДЭЖ БОЛЖ БУЙ:  
Талд хонь БЭЛЧИНЭ.

Талд олон хонь БЭЛЧИЖ БАЙНА.  
Талд олон хонь бэлчиж яваа /юм/  
Бат ОЮУТАН /ЮМ/

МЭДЭГДЭЭГҮЙ БОЛЖ БУЙ:  
Талд олон хонь БЭЛЧИЖ БАЙГАА ЮМ  
БАЙНА.

Бат оюутан /ЮМ/ БАЙНА.  
Талд байгаа хонь олон /ЮМ/ БАЙНА

2. Ирээдүй цагийн утгатай өгүүлбэрүүд мөн л дээрх хоёр баймж харьцааг ялган заана. Үүнд ирээдүй цаг заах өгүүлбэрийн өгүүлэхүүн нь –на (-но, -нэ, -нө) хэлбэрт үйл үг “БОЛНО” гэдэг туслах үйл үгтэй нэрийн зүйл, тэрчлэн БОЛНО, ЮМ, ЮМ БАЙНА гэх мэт туслах үгтэй цагт нэрээр илэрдэг. Эдгээрээс –на (-но, -нэ, -нө) хэлбэртэй үйл үг, БОЛНО гэдэг туслах үгтэй нэрийн зүйл, цагт нэр өгүүлэхүүнтэй өгүүлбэрүүд нь мэдэгдэж болох ирээдүй цагийг зааж, ЮМ БАЙНА гэсэн туслах үгтэй ирээдүй цагт нэр, бас нэрийн зүйлээр илэрсэн өгүүлэхүүнтэй нь мэдэгдээгүй болох ирээдүй цагийн баймж утгыг илтгэнэ. Жишээлбэл:

МЭДЭГДЭЖ БОЛОХ:  
Маргааш олон хонь БЭЛЧИНЭ

МЭДЭГДЭЭГҮЙ БОЛОХ  
Маргааш олон хонь бэлчих ЮМ БАЙНА.

<sup>11</sup> В.А. Звегинцев. Предложение и его отношение к языку и речи. М., 1976. 114, 176-177-р тал.

Олон хонь БЭЛЧИХ БОЛНО            Бат оюутан БОЛОХ ЮМ БАЙНА.  
Ирэх жил Бат ОЮУТАН БОЛНО. Танай хонь улам олон болох ЮМ БАЙНА.  
Маргааш олон хонь БЭЛЧИХ ЮМ.

3. Өнгөрсөн цагийн утгатай хүүрнэх өгүүлбэрт энэ хоёр баймж утгыг үзүүлэхдээ хэрэв яригч этгээдэд уг үйл явдал урьд нь мэдэгдэж байсан бол өгүүлэхүүний нь цаг заах үйлийн –лаа (-лоо, -лээ, -лөө), -в нөхцөл, тэрчлэн цагт нэрийн -сан (-сон, -сэн, -сон) /+юм/ гэсэн хэлбэрүүдээр илрүүлж, уг болж өнгөрсөн үйл явдал яригч этгээдэд урьд мэдэгдээгүй, дөнгөж сая мэдэгдэж буй бол тийм өгүүлбэрийн өгүүлэхүүнийг үйл үгийн –жээ (-чээ), мөн цагт нэрийн -САН (-сон, -сэн, -сон) +БАЙНА, +САН(-сэн, -сон, -сөн) ++ЮМ+БАЙНА гэсэн хэлбэрээр илтгэн гаргана. Жишээлбэл:

#### МЭДЭГДЭЖ БОЛСОН

Талд олон хонь БЭЛЧЛЭЭ  
Талд олон хонь БЭЛЧИВ<sup>12</sup>  
Талд олон хонь БЭЛЧСЭН /ЮМ/  
Бат оюутан БАЙСАН /ЮМ/

#### МЭДЭГДЭЭГҮЙ БОЛСОН

Талд олон хонь БЭЛЧЖЭЭ  
Талд олон хонь БЭЛЧСЭН БАЙНА  
Талд олон хонь БЭЛЧСЭН ЮМ БАЙНА  
Бат оюутан БАЙСАН /ЮМ/ БАЙНА

Дээрх хоёр баймж утга хүүрнэх өгүүлбэрийн зөвхөн батлах хэлбэр дээр төдийгүй мөн үгүйсгэх хэлбэрт ч нэгэн адил байна.

Жишээлбэл: Талд олон хонь эс бэлчлээ. Талд олон хонь бэлчсэнгүй /мэдэгдэж өнгөрсөн/ Талд олон хонь эс бэлчжээ. Бат оюутан байсангүй /мэдэгдээгүй өнгөрсөн/ гэх мэт.

Орчин цагийн монгол хэлэнд хүүрнэх өгүүлбэрийн баймж харьцаанаас шалтгаалж мэдэгдэж буй баймж утгатай өгүүлбэрийн оронд мэдэгдээгүй баймж утгатай өгүүлбэрийг сольж огт хэрэглэдэггүй. Монгол хүн энэ хоёр баймж утгыг маш нарийн ялган хэлэлцдэг зүй тогтолтой юм. Жишээ нь: яригч этгээд өөрөө бороо орохыг үзэж мэдсэн бол МАНАЙ ҮҮГЭЭР БОРОО ОРЛОО, МАНАЙ ҮҮГЭЭР БОРОО ОРЖ БАЙНА. МАНАЙ ҮҮГЭЭР БОРОО ОРНО, МАНАЙ ҮҮГЭЭР БОРОО ОРСОН гэх мэтээр хэлэлцэх бөгөөд, уг үйл явдлаа өөрөө мэдсэн атлаа мэдээгүй дүр үзүүлэхгүй л юм бол МАНАЙ ҮҮГЭЭР БОРОО ОРЖЭЭ. БОРОО ОРЖ БАЙГАА ЮМ БАЙНА. БОРОО ОРЖ БАЙСАН ЮМ БАЙНА. БОРОО ОРЖ БАЙХ ЮМ БАЙНА гэж огт хэлдэггүй журамтай юм.

Мэдэгдсэн ба мэдэгдээгүй үйл явдлыг илэрхийлэх өгүүлбэрүүд нь өөр өөрийн өвөрмөц байрлалтай байх бөгөөд энэ байрлал нь тухайн өгүүлбэрийг хэлэх орчин нөхцөлөөс шууд шалтгаална. Аливаа өгүүлбэр орчинтой нягт холбоотой, түүнийг аль нэг хэлбэрээр заавал тусгана.

Дээрх хоёр баймж утга орчноос хамаарсан өвөрмөц байрлалтай байхаас гадна тус тусын илрэх өвөрмөц хэлбэртэй юм. Энэ хэлбэр нь тухайн өгүүлбэрийн гол цөм болсон өгүүлэхүүнээр илрэнэ. Үүнд мэдэгдээгүй болох баймж харьцааг орчин цагийн монгол хэлэнд тухайн өгүүлбэрийн өгүүлэхүүний дараа ЮМ БАЙНА, БАЙНА, гэсэн туслах үйл үг, мөн -ЖЭЭ (-ЧЭЭ) гэсэн үйлийн хамаатуулах нөхцөлийг хэрэглэж илрүүлдэг ажээ. Зөвлөлтийн эрдэмтэн профессор В.З.Панфилов орчин цагийн монгол хэлэнд бай-

<sup>12</sup> Энэ хэлбэр зөвхөн бичгийн хэлэнд хэрэглэгдэнэ. Ярианд асуух сул үгийн өмнө, бас –даа ( -доо, -дээ, -дөө) гэдэг өгүүлбэрийн нөхцөлийн өмнө болгоомжлох утгаар хэрэглэгдэнэ.

язгууртай туслах үйл үгийг өгүүлбэрийн баймж утгыг илтгэхэд хэрэглэдэг<sup>13</sup> гэж дурдсан нь дээрхийг давхар баталж буй зүйл гэж бодож байна.

Монгол хэлний баймж харьцааг тал бүрээс нь цаашид сайн судлах нь зөвхөн онолын төдийгүй бас практик ач холбогдолтой юм. Ялангуяа гадаад хүнд энэхүү эсэргэ, тэсэргэ хоёр баймж харьцааны ялгааг таниулж, монгол өгүүлбэрийн утга санаа, өнгө аясыг зөв хэрэгжүүлж сургах нь чухал байна.

### **Summary**

This article, written by B. Ragchaa (1927-1980), former professor of the School of Mongolian Language and Culture, National University of Mongolia, has been kept by his student, Yu. Munkh-Amgalan, for the past 30 years.

The article concerns the modal meaning of narrative sentences in Mongolian, discusses the fact that definite and indefinite modal meanings can be expressed in the past, present, and future tenses, in either affirmative or negative forms.

---

<sup>13</sup> В. З. Панфилов. Дурдсан зохиолын 188-р тал.